

МБСХ-НЫ ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ

1-р зүйл. Хяналтын байгууллага

Монголын бүжгийн спортын холбоо (МБСХ) бол Монгол улсын МБСХ Бүжгийн спортын бүх тэмцээнүүдийн удирдах байгууллага мөн.

2-р зүйл. Хэрэгжилт

2.1. Эдгээр дүрэм нь МБСХ-ны гишүүдийн зохион байгуулж буй Бүжгийн спортын бүхий л тэмцээнүүдэд хамаарна. Стандартын, Латин-Америкийн, Шинэ загварын, Америк загварын, Рокн ролл, Хуучин цагийн, Орчин цагийн бүжгүүдээр хязгаарлагдахгүй.

2.2. МБСХ-ны Тэргүүлэгчид энэхүү дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй.

2.3. Тусгай үйл ажиллагааны үед Тэргүүлэгчид нэмэлт дүрэм, журам боловсруулж болно.

2.4. МБСХ-ны бүх тэмцээнд оролцогчид нь МБСХ-ны гишүүн байх ёстой.

3-р зүйл. Мөнгөн шагнал

МБСХ Улсын аварга шалгаруулах тэмцээнд МБСХ-ноос мөнгөн шагнал гаргаж болно. Аливаа тэмцээнийг зохион байгуулагчид мөнгөн шагнал гаргах саналтай байгаа бол МБСХ-ны Тэргүүлэгчдээс зөвшөөрөл авах хэрэгтэй.

4-р зүйл. Сурталчилгаа

4.1. МБСХ-гоор зөвшөөрөгдсөн Бүжгийн спортын тэмцээний үед хос бүр өөрсдийн хувцасны 40см.кв хүртэл талбайд 2 хүртэл ивээн тэтгэгчийг сурталчлахыг зөвшөөрнө. Сурталчилгааг бэлхүүс, цээж эсвэл ханцуйн дээр байрлуулна. Сурталчилгаа нь эрэгтэй эмэгтэйн аль нэгний хувцсан дээр эсвэл тус бүрийн хувцсан дээр нэг нэг ивээн тэтгэгчийнх байрлаж болно.

4.2. Хосуудын тэмцээний дугаар дээрх сурталчилгаа нь дугаарын хэмжээний 20%-иар хязгаарлагдана.

5-р зүйл. Тэмцээний зэрэглэл

5.1. МБСХ Улсын аварга шалгаруулах тэмцээнүүд (насанд хүрэгчид, залуучууд, өсвөр нас, хүүхэд нас)

Тэмцээний ангилал:

5.1.1. Стандартын бүжгүүд (Вальс, Танго, Венийн вальс, Удаан фокстрот, Хурдан фокстрот)

5.1.2. Латин-Америкийн бүжгүүд (Самба, Ча-ча-ча, Румба, Пасодобль, Жайв)

5.1.3. 10 бүжиг (Стандартын ба Латин-Америкийн)

5.1.4. Формейшн (Стандартын ба Латин-Америкийн), зөвхөн насанд хүрэгчид

Урилга: Урилгыг МБСХ-ны бүх гишүүн холбоо, клубуудад илгээнэ.

5.2. МБСХ Цомын аварга шалгаруулах тэмцээн

Тэмцээний ангилал:

5.2.1. Стандартын бүжгүүд (Вальс, Танго, Венийн вальс, Удаан фокстрот, Хурдан фокстрот)

5.2.2. Латин-Америкийн бүжгүүд (Самба, Ча-ча-ча, Румба, Пасодобль, Жайв)

5.2.3. 10 бүжиг (Стандартын ба Латин-Америкийн)

5.2.4. Формейшн (Стандартын ба Латин-Америкийн), зөвхөн насанд хүрэгчид

Урилга: Урилгыг МБСХ-ны бүх гишүүн холбоо, клубуудад илгээнэ.

5.3. МБСХ Бүсийн болон Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнүүд

5.3.1. Стандартын бүжгүүд (Вальс, Танго, Венийн вальс, Удаан фокстрот, Хурдан фокстрот)

5.3.2. Латин-Америкийн бүжгүүд (Самба, Ча-ча-ча, Румба, Пасодобль, Жайв)

5.3.3. 10 бүжиг (Стандартын ба Латин-Америкийн)

5.3.4. Формейшн (Стандартын ба Латин-Америкийн), зөвхөн насанд хүрэгчид

Урилга: Урилгыг МБСХ-ны бүх гишүүн холбоо, клубуудад илгээнэ.

Энд тодорхой зэрэглэлийн тэмцээнүүд орно. Тамирчны ур чадварын зэрэглэл ба насны ангилалын дүрмийг мөрдөх ёстой. Тамирчны ур чадварын зэрэглэл ба насны ангилалын дүрэм нь МБСХ-ны Тэмцээний дүрмийн бүрэлдэхүүн хэсэг мөн.

5.4. Улсын чанартай нэрэмжит тэмцээнүүд

Тэмцээний ангилал:

5.4.1. Стандартын бүжгүүд (Вальс, Танго, Венийн вальс, Удаан фокстрот, Хурдан фокстрот)

5.4.2. Латин-Америкийн бүжгүүд (Самба, Ча-ча-ча, Румба, Пасодобль, Жайв)

Урилга: Урилгыг МБСХ-ны бүх гишүүн холбоо, клубуудад илгээнэ.

Энд тодорхой зэрэглэлийн тэмцээнүүд орно. Тамирчны ур чадварын зэрэглэл ба насны ангилалын дүрмийг мөрдөх ёстой.

Бүжгүүдийн зөвшөөрөгдсөн хугацаа ба хэмнэл:

МБСХ-ны зөвшөөрөгдсөн бүжиг ба хөдөлгөөний тухай дүрмийг мөрдөх ёстой. Зөвшөөрөгдсөн бүжиг ба хөдөлгөөний тухай дүрэм нь МБСХ-ны Тэмцээний дүрмийн бүрэлдэхүүн хэсэг мөн.

Тэмцээн дээр тоглогдож буй хөгжим нь Вальс, Танго, Удаан фокстрот, Хурдан фокстрот, Самба, Ча-ча-ча, Румба, Пасодобль бүжгүүдэд хамгийн багадаа нэг минут хагас байна. Харин Венийн вальс, Жайв бүжгүүдийн хувьд нэг минут байна.

Бүжиг бүрийн хувьд хэмнэл нь:

Вальс	28-30такт/мин	Самба	50-52такт/мин
Танго	31-33такт/мин	Ча-ча-ча	30-32такт/мин
Венийн вальс	58-60такт/мин	Румба	25-27такт/мин
Удаан фокстрот	28-30такт/мин	Пасодобль	60-62такт/мин
Хурдан фокстрот	50-52такт/мин	Жайв	42-44такт/мин

Хөгжмийн төрөл:

МБСХ-ны бүх тэмцээн дээр тоглогдож буй хөгжим нь тухайн бүжгүүдийн онцлогийг илэрхийлж байх ёстой. Жишээ нь Латин-Америкийн бүжгүүдэд диско хөгжим байж болохгүй.

Хөдөлгөөний хязгаарлалт

МБСХ-ны зэрэглэлийн тэмцээнүүдэд бүжгийн хөдөлгөөнийг хязгаарлаж өгнө. Зөвшөөрөгдсөн бүжиг ба хөдөлгөөнүүдийн тухай дүрмийг мөрдөх ёстой. МБСХ-ноос томилогдсон Ерөнхий шүүгч хөдөлгөөний хязгаарлалтад хяналт тавина.

6-р зүйл. Тэмцээнийг зохион байгуулах эрх

Тэргүүлэгчдээс 5-р зүйлийн 5.1, 5.2, 5.3, 5.4-р заалтуудад заагдсан тэмцээнүүдийг зохион байгуулах эрх олгож татвар авна. МБСХ-ны санхүүгийн журмыг хар. Онцгой тохиолдолд Тэргүүлэгчид нь гишүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг шууд олгох эрх эдэлнэ.

Тэмцээн зохион байгуулагчид МБСХ-ны Тэмцээн уралдаан зохион байгуулах эрх олгох, зохион байгуулагчдад хүлээлгэх үүргийн тухай журмыг мөрдөх ёстой. Тэмцээн уралдаан зохион байгуулах эрх олгох, зохион байгуулагчдад хүлээлгэх үүргийн тухай журам нь МБСХ-ны Тэмцээний дүрмийн бүрэлдэхүүн хэсэг мөн.

7-р зүйл. Допинг

МБСХ-ны Анти-Допингийн дүрмийн нөхцөл ёсоор Допингийг хатуу хориглоно.

8-р зүйл. Тэмцээнүүдийг явуулах журам

8.1. МБСХ-ны Тэргүүлэгчдээс томилсон Ерөнхий шүүгч нь МБСХ-ноос эрх олгосон тэмцээнүүдэд хяналт тавих үүрэгтэй. Тэмцээний Ерөнхий шүүгч МБСХ-ноос томилогдоогүй тохиолдолд зохион байгуулагч Ерөнхий шүүгчийг томилох ёстой.

8.2. Шүүгчид:

Хосын аварга шалгаруулах тэмцээнийг долоон шүүгч (онцгой тохиолдолд ес ба түүнээс олон), Формейшн буюу хамтлагийн тэмцээнийг таван шүүгч (онцгой тохиолдолд долоон шүүгч) шүүнэ.

Шүүгчид МБСХ-ны Шүүгчдийн коллегийн журам, Шүүгчдийн зан байдлын гоо зүйн хэм хэмжээ ба дүрмийг мөрдөнө.

9-р зүйл. Насны хязгаарлалт

9.1. МБСХ-ны Тэмцээнүүдийн үед доорхи насны ангилалыг мөрдөх журамтай:

Хүүхэд нас - 1:	9 нас болон түүнээс бага
Хүүхэд нас - 2:	10-аас 11 настай
Өсвөр нас -1:	12-оос 13 настай
Өсвөр нас -2:	14-өөс 15 настай
Залуучууд:	16, 17, 18 настай
Насанд хүрэгчид:	19 нас болон түүнээс дээш
Ахмад нас - 1:	35 нас болон түүнээс дээш
Ахмад нас - 2:	45 нас болон түүнээс дээш

9.2. Гишүүд МБСХ-ны Тамирчны ур чадварын зэрэглэл ба насны ангилалын дүрмийг мөрдөх ёстой.

10-р зүйл. Тэмцээний хувцаслалт

5-р зүйлийн дагуу МБСХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн бүх тэмцээнд оролцогчдын хувцас МБСХ-ны Спортын хувцасны журамд нийцсэн байх ёстой. Энэхүү Спортын хувцасны журам нь МБСХ-ны Тэмцээний дүрмийн бүрэлдэхүүн хэсэг мөн.

Ерөнхий шүүгч эсвэл МБСХ-ны Спорт эрхэлсэн захирал нь энэ дүрэмд харш хувцасласан тэмцээнд оролцогчдын гүйцэтгэх эрхийг хасах эрх эдэлнэ. Мөн Тэргүүлэгчид нь ийм хосын тэмцээнд оролцох эрхийг тодорхой хугацаагаар хасах эрх эдэлнэ.

11-р зүйл. Хосууд

Хосын тодорхойлолт: Хос нь эрэгтэй эмэгтэй партнераас бүрдэнэ.

Холимог үндэстнээс бүрдэх хосууд:

1. Олон улсын тэмцээнд оролцож байгаа аливаа хос нь зөвхөн нэг улсыг төлөөлөх ёстой.

2. ОУБСХ-ны АШТ эсвэл ОУБСХ-ны цомын тэмцээнд Нэг улсыг төлөөлж буй хосууд 12 сарын хугацаанд өөр улсыг төлөөлөхийг үл зөвшөөрнө.

3. Олон Улсын Олимпийн Хороо (International Olympic Committee - IOC) болон Дэлхийн наадмын Олон улсын холбоо (International World Game Association)-ны үйл ажиллагааны хүрээнд зохиогдож буй тэмцээнд холимог үндэстнээс бүрдэх хосыг үл зөвшөөрнө. Олимпийн дүрмийн дагуу тэмцээнд оролцогчид өөр өөрсдийн үндэстэнг төлөөлнө. Тэмцээнд оролцогч бүр ОУБСХ-ны гишүүн холбоог төлөөлж буйг батлах иргэний харъяалал (паспорт)-тай байх ёстой.

4. ОУБСХ-ны АШТ эсвэл ОУБСХ-ны цомын тэмцээнд оролцож байгаа багийн дор хаяж 12 тамирчин нь тухайн ОУБСХ-ны гишүүн холбоог төлөөлсөн үндэстэн (паспортой) байх ёстой.

12-р зүйл. Тэргүүлэгчдийн бүрэн эрх

Тэргүүлэгчид энэхүү дүрэмд багтаагүй асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй.

13-р зүйл. Энэхүү дүрмийн хэрэгжилт

МБСХ-ны гишүүд нь МБСХ-ны тэмцээний дүрмийг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд энэхүү дүрмийг өөрсдийн дүрмийн чиг, удирдамж болгон ашиглана.

Энэхүү журмыг 2009 оны 1-р сарын 15-ны өдрийн МБСХ-ны Бүх гишүүдийн хураар хэлэлцэж батлав.